

**ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2021, 2022 ОНЫ
САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНГУУДАД ХЯНАЛТ ШАЛГАЛТ
ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

2023.04.20

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нийгмийн даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт заавар журам, норм нормативын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд чиглэгдэнэ.

ХОЁР. ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Шалгалтыг Монгол улсын Сангийн сайдын 2023 оны 3 дугаар сарын 23 өдрийн СХШХ/02 тоот удирдамж, аймгийн Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 24 өдрийн СХШХ/03 тоот удирдамжийн дагуу Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч С.Бархасмаа, Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Б.Батсайхан, С.Энхтайван, байцаагч А.Нямгэрэл нарын бүрэлдэхүүнтэйгээр 2023 оны 03 дугаар сарын 27-ноос ажлын 20 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

ГУРАВ. ХАМРАГДСАН АСУУДАЛ

Шалгалтыг 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагааны холбогдох баримтад тулгуурлан төсөвт байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг шалгаж үнэлэлт дүгнэлт өгсөн. Үүнд:

1. Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт;
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт;
3. Сангуудын орлогын төрөл, төвлөрүүлэлт, түүний зарцуулалт, үр дун;
4. Харилцах болон бэлэн мөнгөний дансны орлого, зарлагын гүйлгээ болон бэлэн мөнгөний удирдлагын нөхцөл байдал, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт;
5. Ажилтан, албан хаагчдад олгож буй цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, түүнтэй адилтгах бусад орлого болон байгууллагын хэрэгцээний карт ашиглалт, зарцуулалтын нөхцөл байдал, шийдвэр, үндэслэл, тэдгээрт хяналт тавьж буй байдал;
6. Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлагнал, төлөлтийн байдал;
7. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, өглөгийн насжилт, өглөг үүсгэж буй үндэслэл, өр, авлага барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;
8. Эрх бүхий байгууллагаас өмнө хийгдсэн хяналт шалгалт, аудитын дүгнэлт, шийдвэр, акт, зөвлөмжийн хэрэгжилт;
9. Байгууллага иргэдтэй байгуулсан гэрээний үндэслэл, гэрээний үүргийн хэрэгжилт, түүнийг дүгнэсэн байдал;
10. Хөрөнгө оруулалт, төслийн санхүүжилтийн үндэслэл, бүртгэл, холбогдох шийдвэр гаргалт, тооцоо нийлж буй байдал, гэрээ, хэлцэл хийх журам, хэрэгжилт, тэдгээрт тавих хяналт;
11. Төсвийн тухай хууль, нийгмийн даатгалын тухай хуулиуд болон холбогдох журмууд хэрхэн хэрэгжиж байгаа байдалтай танилцаж, тулгарч буй асуудлуудыг дүгнэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг засаж сайжруулах

ДӨРӨВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН МӨРӨӨР АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Манай албаны 2019 оны хяналт, шалгалтаар 7 зөвлөмж өгч ажилласан ба зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаандаа албан тоотой өгөгдсөн боловч 1 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, дахин давтан гаргасаар байна. Энэ нь худалдан авсан бараа материалыг шаардах хуудсаар гаргахдаа гарын үсгийн иж бүрдэлгүй анхан шатны баримтаар зарлага гаргасан байна. Орлогын болон зарлагын баримт үйлдэж хавсаргаагүй тайлан гаргадаг. Бараа материалыг бүрэн орлогоддоггүй шууд зардал тайлагнадаг зөрчил арилаагүй байна.

Төрийн аудитын газраас 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийгдэж “Зөрчилгүй” дүгнэлт өгөгдсөн ба шилэн дансны 3 мэдээлэл хугацаа хоцроосон, 16 мэдээлэл байршуулаагүй зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлсэн, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгч 1 албан хаагчийн цалинг 7 дугаар сарын нийгмийн даатгалын тайланд 30.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, түлшний үнийн хөнгөлөлтийн ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 232.5 мянган төгрөгийг тушаал шийдвэргүй шилжүүлсэн нийт 262.5 мянган төгрөгийн зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлсэн байна.

ТАВ: ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Дундговь аймгийн хэлтэс нь Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, ажил олгогч, даатгуулагчдыг нийгмийн даатгалд хамруулах, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хуулиар тогтоосон хугацаанд олгох, цахим үйлчилгээг нэвтрүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэн 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий даатгагч болох зорилготой ажиллаж байна.

Тус байгууллага нь 2021 онд удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 32, үйлчлэх ажилтан 5 нийт 38 хүний орон тоотой ажилласан байна.

2022 онд удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 31, үйлчлэх ажилтан 4 нийт 36 хүний орон тоотой ажилласан.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга болон аймгийн Засаг даргатай байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг тооцон ажилласан байна. Байгууллагын дарга ажилтан, албан хаагчидтай гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээ байгуулан бүтэн жилээр нэг удаа дүгнэн урамшуулал 20-55 хувиар 10,677.5 мянган төгрөг олгосон байна. Энэ нь ЗГ-ын 2020 оны 218 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтын 4.1-д “Байгууллагын үнэлгээний багийг төсвийн шууд захирагчийн шийдвэрээр байгууллагын нэгжийн удирдах албан тушаалтан болон хүний нөөц хариуцсан албан хаагчийн төлөөллөөс бүрдүүлэн жил бүрийн 6, 12 дугаар сард багтаан байгуулна. Хэрэв тухайн байгууллага зохион байгуулалтын нэгжгүй бол байгууллагын үнэлгээний баг шаардлагагүй бөгөөд энэ журамд заасан байгууллагын үнэлгээний багийн хийх ажлыг төсвийн шууд захирагч гүйцэтгэнэ” заасан заалтыг зөрчин хагас жилээр дүгнээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 16.4.18-д заасны дагуу 2021, 2022 оны санхүүгийн баримтад нэг, хоёр дугаар гарын үсгийн дараах албан хаагчид зурсан байна.

Байгууллагын нэр	Хугацаа	1-р гарын үсэг	2-р гарын үсэг
Нийгмийн даатгалын хэлтэс	2021.01.01-2022.12.31	Г.Батжаргал	Р.Нэргүй

ЗУРГАА: ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13.1-д байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч нь холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, тухайн хурал, Засаг даргын болон өөрийн шийдвэрийг байгууллагынхаа хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, дотоод хяналт шалгалтын журам тогтоож ажиллана, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67.1-д "төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлд "нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх талаар заасан заалтын дагуу дотоод хяналтын нэгжийг байгуулна" гэж тус тус заасны дагуу хяналт шалгалтын төлөвлөгөө гарган батлуулж шалгалтыг тогтмол хийж хэвшсэн сайн туршлага байна.

2022 онд дотоод хяналт, шалгалтаар дараах зөрчил дутагдлыг илрүүлж зөрчлийг арилгасан байна. /Хүснэгтээр харуулбал/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Тайлангийн хугацаанд		Улирлын эцсийн үлдэгдэл			
		Шалгаж илрүүлсэн төлбөрийн дүн	Барагдуулсан төлбөрийн дүн				
Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт	Шалгалтанд хамрагдсан	Бай/-ын тоо	1	198			
		Даат/ын тоо	2	4230			
	Нуусан буюу хэмжээг нь санаатай бууруулсан хөдөлмөрийн хөлс орлогод ногдох шимтгэл	Бай/-ын тоо	3	23	23		
		Даат/ын тоо	4	86	86		
		дүн		6,412.9	6,412.9		
		Бай/-ын тоо	7	4	4		
	Дутуу буюу хугацаандаа төлөгдөөгүй шимтгэл	Даат/ын тоо	7	4	4		
		дүн		1,059.3	1,059.3		
	Тооцооны алдаа гарснаас дутуу телсен шимтгэл	Бай/-ын тоо	9				
		Даат/ын тоо	10				
		дүн	11				
	Ногдуулсан алданги	Бай/-ын тоо	12	23	23		
		Даат/ын тоо	13	2000	2000		
		дүн	14	36,936.2	36,936.2		
	Торгууль	Бай/-ын тоо	15	15	15		
		Даат/ын тоо	16	159	159		
		дүн	17	1,600.0	1,600.0		
	Байгууллагын тоо	18	23	23			
	Даатгуулагчийн тоо	19	90	90			
	Төлбөр, алдангийн дүн	20	46,008.4	46,008.4	0.0		
Тэтгэвэр тогтоолт, олголт	Шалгалтанд хамрагдсан	Х/хэргийн тоо	21	609	15	15	
		Хуний тоо	22	4	15	1	2
	Илүү олгосон тэтгэвэр	дүн	23	9,510.7	6,601.9	9,975.8	6,136.8
		Хуний тоо	24			1	
	Дутуу олгосон тэтгэвэр	дүн	25		145.8	145.8	
		Хуний тоо	26				
	Ногдуулсан торгууль	дүн					
		Хуний тоо	28		16	18	2
		Төлбөрийн дүн	29	9,510.7	6,747.7	9,975.8	6,136.8
	Тэтгэмжийн бодолт, олголт ХЧТА Олшигдла	Шалгалтанд хамрагдсан	Хуний тоо	30	141	18	17
Бай/-ын тоо			31				
Илүү олгосон тэтгэмж		Хуний тоо	32		18	17	1
		дүн	33		6,719.8	6,459.8	260.0
Дутуу олгосон тэтгэмж		Хуний тоо	34				
		дүн	35				
Ногдуулсан торгууль		Хуний тоо	36				
		Бай/-ын тоо	37				
	дүн	38					

		Хүний тоо/32+34/	39		18	17	1	
		Төлбөрийн дүн/33+35/	40	0.0	6,719.8	6,459.8	260.0	
Хэлтсийн үйл ажиллагааны зардалын	Хөрөнгө ашигласан	Хүний тоо	64		39	39		
		дүн	65		39	39		
	Урамшууллын акт	Хүний тоо	66					
		дүн						
	Ногдуулсан торгууль	Хүний тоо	68					
		Бай/-ын тоо	69					
		дүн	70					
			хүний тоо/32+34/					
			Төлбөрийн дүн/33+35/	72				
			НИЙТ ХҮНИЙ ТОО / 19+28+39+52+71/	73		124	125	
		Нийт ажил олгогч, эмнэлгийн байгууллагын тоо/18+53/	74		23	23		
		НИЙТ ТӨЛБӨРИЙН ДҮН /20+29+40+54+63+72/	75	9,510.7	59,475.9	62,444.0	6,396.8	
		хүний тоо 5+26+36+49+60+68/	76		15			
Торгууль /Бүгд/	Бай/-ын тоо/16+37+50+61 +69/		77		159	159		
	дүн/17+27+38+51+62+70/		78		1,600.0	1,600.0		

ДОЛОО. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР 2021 оны санхүүгийн тайлангаар:

Улсын төсвөөс 25,982,585.6 мянган төгрөг, татварын бус орлого 103,476.1 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 18,200,965.2 мянган төгрөг нийт 44,287,027.0 мянган төгрөгийн орлогын эх үүсвэртэй ажиллаж үйл ажиллагаандаа зарцуулсан байна. 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 100,697.5 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн.

Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,648,507.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 442,289.5 мянган төгрөгөөр буурсан нь Нийгмийн даатгалын сангаас ковидын нөхцөл байдлаас шалтгаалан тэтгэмжийн болон ажилгүйдлийн сангийн зардал өндөр гарсантай холбоотой байна.

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн	5,970,865.4	6,096,134.9	125,269.5
Мөнгөн хөрөнгө	4,090,796.5	3,648,507.0	(442,289.5)
Авлага	1,865,097.6	2,432,073.4	566,975.8
Бараа материал	14,971.3	15,554.5	583.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	472,437.2	447,865.2	(24,572.0)
Үндсэн хөрөнгийн дүн	472,437.2	447,865.2	(24,572.0)
Нийт хөрөнгийн дүн	6,443,302.6	29,434.3	100,697.5
Нийт өр төлбөр	137,065.0		(107,630.8)
Богино хугацаат өр төлбөр	137,065.0	29,434.3	(107,630.8)
Цэвэр хөрөнгийн өмчийн дүн	6,306,237.6	6,514,565.8	208,328.3
Засгийн газрын хувь оролцоо	6,306,237.6	6,514,565.8	208,328.3
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,443,302.6	6,544,000.1	100,697.5

Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр Нийгмийн даатгалын сангийн төсвөөс 17.9 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр дээд шатны төсөв захирагчаас 25,960,788.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийгмийн даатгалын сангийн орлогоос 18,761,949.0 мянган төгрөгийг санхүүжүүлж, нийт гүйцэтгэлээр 40,433,037.4 мянган төгрөгийг зарцуулж, 4,289,699.6 мянган төгрөгийг дээд шатны байгууллагад төвлөрүүлсэн байна.

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,540,517,900.00	40,433,037,408.51	107,480,491.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	40,540,517,900.00	40,433,037,408.51	107,480,491.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	560,071,700.00	538,076,405.99	21,995,294.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	420,709,700.00	413,419,287.65	7,290,412.35
210101	Үндсэн цалин	328,837,400.00	322,766,303.11	6,071,096.89
210102	Нэмэгдэл	64,748,300.00	64,696,984.54	51,315.46
210103	Унаа хоолны хонгодолт	20,644,000.00	19,476,000.00	1,168,000.00
210104	Урамшуулал	6,480,000.00	6,480,000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,553,200.00	53,918,824.00	634,376.00
210201	Тэтгэврийн даатгал	37,767,600.00	37,306,434.32	461,165.68
210202	Тэтгэмжийн даатгал	4,196,400.00	4,151,749.45	44,650.55
210203	ҮОМШО-ний даатгал	3,357,100.00	3,321,399.56	35,700.44
210204	Ажилгүйдлийн даатгал	839,300.00	830,349.89	8,950.11
210205	Эрүүл мэндийн даатгал	8,392,800.00	8,308,890.78	83,909.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,631,500.00	32,494,846.46	136,653.54
210301	Гэрэл, цахилгаан	1,342,000.00	1,209,626.46	132,373.54
210302	Түлш, халаалт	30,307,200.00	30,307,200.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	982,300.00	978,020.00	4,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,252,500.00	16,521,629.38	3,730,870.62
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	5,000,000.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	9,210,000.00	6,852,730.00	2,357,270.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,000,000.00	1,675,937.38	1,324,062.62
210405	Хөгжлийн зардал, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	542,500.00	502,992.00	39,508.00
210406	Бага үнгэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	2,489,970.00	10,030.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	994,800.00	1,505,200.00
210601	Багаж, техник хэрэгсэл	1,500,000.00	0.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	994,800.00	5,200.00
2107	Томилголт, зочны зардал	2,207,800.00	817,000.00	1,390,800.00
210702	Дотоод албан томилголт	2,207,800.00	817,000.00	1,390,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,217,000.00	17,930,598.50	7,286,401.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,053,300.00	12,782,991.50	4,270,308.50
210802	Лудит, баталгаажуулалт, зэрлэг тогтоох	2,300,000.00	0.00	2,300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	558,500.00	558,450.00	50.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,400.00	71,340.00	60.00
210807	Газрын төлбөр	120,100.00	120,037.00	63.00

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,113,700.00	4,397,780.00	715,920.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,979,420.00	20,580.00
210902	Хивсгэл үйлдвэр, гэмийн дадлага хийх	2,000,000.00	1,979,420.00	20,580.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,980,446,200.00	39,894,961,002.52	85,485,197.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,980,446,200.00	39,894,961,002.52	85,485,197.48
213202	Нийгмийн даатгалын гэггээр, гэггэмж	39,972,946,200.00	39,887,470,689.52	85,475,510.48
213204	Ажил олгогчдоос олгох бусад гэггэмж, урамшуулал	7,500,000.00	7,490,313.00	9,687.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	40,540,517,900.00	15,673,293,905.67	24,867,223,994.33
31	УЛСЫН ТӨСВООС САНХҮҮЖИХ	7,022,564,600.00	21,512,600.00	7,001,052,000.00
310001	Улсын төсвоос санхүүжих	7,022,564,600.00	21,512,600.00	7,001,052,000.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВООС САНХҮҮЖИХ	33,517,953,300.00	15,610,949,139.84	17,907,004,160.16
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	33,517,953,300.00	15,610,949,139.84	17,907,004,160.16
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	40,832,165.83	-40,832,165.83
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	40,519,338.61	-40,519,338.61
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	312,827.22	-312,827.22
4	Монго, түүнтэй адилгах хоронгийн эхний үлдэгдэл	0.00	4,090,796,504.12	-4,090,796,504.12
5	Монго, түүнтэй адилгах хоронгийн эцсийн үлдэгдэл	0.00	3,648,506,978.39	-3,648,506,978.39
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	77.00	77.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38.00	38.00	0.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	32.00	32.00	0.00
620003	Үйлчрэх ажилтан	5.00	5.00	0.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38.00	38.00	0.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ГЗ)	33.00	33.00	0.00

Үндсэн хөрөнгийн талаар:

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 447,865.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 24,572.0 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлээ бүрэн нөхсөн 19,520.2 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийг данснаас хасаж 15,501.5 сая төгрөгөөр дахин үнэлж, орлого авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансанд НДЕГ-аас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 6,820.2 мянган төгрөг, элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлж орлого авсан 15,501.5 мянган төгрөг, нийт 22,321.7 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч, 48,141.4 мянган төгрөгийн хөрөнгийг актлан данснаас хассан байна.

Авлагын тайлангийн талаар:

Авлагын дансны үлдэгдэл 2,432,073.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 566,975.8 мянган төгрөгөөр өссөн нь төлбөртэй үйлчилгээний авлага буюу аж ахуйн нэгж байгууллагаас авах авлага нэг дахин өссөн, татаас санхүүжилтийн авлага буюу дээд шатны байгууллагаас нөхөн олгох төлбөрийн санхүүжилтийн авлага өссөн байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн орлого бүрдүүлэлт:

Санхүүгийн тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 18,750,353.2 мянган төгрөг, татварын бус орлого 64,999.3 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 25,970,063.4 мянган төгрөгөөр тайлагнажээ. Үүнээс арилжааны банкны хүүгийн орлого 8,375.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 6 дахин буурсан, үндсэн үйл ажиллагааны орлого 36,010.4 мянган төгрөг болж 1 дахин өссөн байна. Энэ нь ковидын нөхцөл байдлаас шалтгаалан 2021 онд арилжааны банкны хүүг зогсоосон мөн 2020 онд ковидын нөхцөл байдлаас шалтгаалан нийгмийн даатгалын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй, алданги, торгуулийг зогсоосон зэргээс шалтгаалсан байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт:

Нийгмийн даатгалын санд 13,928,376.1 мянган төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 15,673,293.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 112.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Сангийн орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэвэр	12,195,959.6	13,601,167.3	1,405,207.70	111.5
Тэтгэмж	970,287.0	1,134,602.7	164,315.70	116.9
ҮОМШӨ	577,772.8	718,691.9	140,919.10	124.4
Ажилгүйдэл	184,356.7	218,832.0	34,475.30	118.7
Дүн	13,928,376.1	15,673,293.9	1,744,917.80	112.5

2022 оны санхүүгийн тайлангаар:

Улсын төсвөөс 44,046,252.4 мянган төгрөг, татварын бус орлого 56,930.4 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 18,429,437.5 мянган төгрөг нийт 62,532,620.3 мянган төгрөгийн орлогын эх үүсвэртэй ажиллаж үйл ажиллагаандаа зарцуулсан байна. 2022 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,033,246.1 мянган төгрөгөөр буюу 31.0 хувиар өссөн.

Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,817,938.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,169,431.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Балансын узуулэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Оорчлолт
	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн	6,096,134.9	8,099,341.7	2,003,206.8
Мөнгөн хөрөнгө	3,648,507.0	5,817,938.3	2,169,431.3
Авлага	2,432,073.4	2,265,217.1	(166,856.3)
Бараа материал	15,554.5	16,186.3	631.8
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	447,865.2	477,904.6	30,039.4
Үндсэн хөрөнгийн дүн	447,865.2	477,904.6	30,039.4
Нийт хөрөнгийн дүн	6,544,000.1	8,577,246.2	2,033,246.1
Нийт өр төлбөр	29,434.3	64,990.4	35,556.1
Богино хугацаат өр төлбөр	29,434.3	64,990.4	35,556.1
Цэвэр хөрөнгийн өмчийн дүн	6,514,565.8	8,512,255.8	1,997,690.0
Засгийн газрын хувь оролцоо	6,514,565.8	8,512,255.8	1,997,690.0

ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,544,000.1	8,577,246.2	2,033,246.1
--	-------------	-------------	-------------

Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр Нийгмийн даатгалын сангийн төсвөөс 54,325,911.3 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр дээд шатны төсөв захирагчаас 36,954,909.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийгмийн даатгалын сангийн орлогоос 15,470,205.0 мянган төгрөгийг санхүүжүүлж, нийт гүйцэтгэлээр 53,317,484.1 мянган төгрөгийг зарцуулж, 7,012,886.1 мянган төгрөгийг дээд шатны байгууллагад төвлөрүүлсэн байна.

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	54,325,911.3	53,317,484.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	54,325,911.3	53,317,484.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	607,588.8	597,022.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	459,920.8	453,826.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,490.1	57,300.6
2103	Байр ашиглалттай холбоотой тоггмол зардал	31,527.2	31,333.4
2104	Хангамж, бараа материалын зардал	25,410.7	23,379.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,405.4	20,395.0
2107	Томилолт, зочны зардал	1,392.7	1,392.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,541.9	8,400.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,900.0	994.5
213	УРСГАЛ ШИЛҮҮЛЭГ	53,718,322.5	52,720,462.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,718,322.5	52,720,462.1
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	54,325,911.3	22,005,956.3
31	УЛСЫН төсвөөс САНХҮҮЖИХ	6,481,024.1	6,481,024.1
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН төсвөөс САНХҮҮЖИХ	47,844,887.2	15,470,205.0
35	төсөвт БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		54,727.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,648,506.9
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		5,817,938.2
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	77	73
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байлага	1	1
62	АЖИЛЛАГСА ҮН ТОО	38	36
620001	Уди дах ажилтан		1
620002	Гүйцэтгэх ажилтан	32	31
620003	Үйлчлэх ажилтан	5	4

Үндсэн хөрөнгийн талаар:

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 477,904.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 30,039.4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь НДЕГ-аас 62,237.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авсантай холбоотой байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн орлого бүрдүүлэлт:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 18,800,632.2 мянган төгрөг, татварын бус орлого 53,077.4 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан 25,970,063.4 мянган төгрөгийн орлогыг тайлагнажээ. Үүнээс арилжааны банкны хүүгийн орлого 156.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 98.1 хувиар буурсан, үндсэн үйл ажиллагааны орлого 36,010.4 мянган төгрөг болж 2.5 хувиар мөн буурсан байна. Энэ нь ковидын нөхцөл байдлаас шалтгаалан 2022 онд арилжааны банкны хүүг зогсоосон, Нийгмийн даатгалын хэлтсээс хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо буурсан зэргээс шалтгаалсан байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт:

Нийгмийн даатгалын санд 15,864,725.4 мянган төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 15,518,058.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 98.0 хувьтай буюу 346,667.2 мянган төгрөгөөр төлөвлөгөө тасарсан байна. Энэ нь малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд нийгмийн даатгалд шимтгэл төлөх бололцоо муудсан, эдийн засгийн чадавхгүй болсон учир сайн дурын даатгалын орлогын төлөвлөгөө биелээгүйтэй холбоотой байна.

Сангийн орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэвэр	13,281,031.3	13,061,940.3	219,091.0	98.4
Тэтгэмж	1,311,487.3	1,340,433.9	(28,946.6)	102.2
УОМШО	1,047,196.8	876,468.6	170,728.2	83.7
Ажилгүйдэл	225,010.0	239,215.4	(14,205.4)	106.3
Дүн	15,864,725.4	15,518,058.2	346,667.2	97.8

НАЙМ. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧИЛ

1. Сангуудын тэтгэвэр, тэтгэмж олголтыг түүвэрлэн программын шивэлт болон хувийн хэргийн бүрдэл тэтгэвэр тогтоосон дүнтэй тулган, банкны мөнгө олголтын жагсаалттай тулган баталгаажуулсан. Тухайн баталгаажуулалтаар 5363 кодтой 1995 оноос өмнөх үйлдвэрийн ослын тэжээгчээ алдсаны тэтгэмжийн тэтгэвэр тогтоолгосон Намхай овогтой Дашхорол /зю62092402/ нь хувийн хэргийн бүрдүүлэлт тогтоолтоор баталгаажсан боловч банк руу тэтгэвэр олгох жагсаалтаар дүү болох Намхай овогтой Отгонсүх /ЗЮ70083105/ -ийн дансанд шилжүүлсэн байна.

Намхай овогтой Отгонсүх /ЗЮ70083105/ нь 2015 оны 11 дүгээр сарын 27 өдөр эгч Намхай овогтой Дашхорол /зю62092402/ тэтгэвэр тэтгэмжийг ХААН банкнаас хүлээн авах, тэтгэвэр барьцаалан зээл авах, зээлийн гэрээ болон холбогдох баримт бичигт төлөөлөн гарын үсэг зурах эрхийг олгосон итгэмжлэл хийлгэжээ. Итгэмжлэлийн хугацаа 3 жил хүчинтэй бөгөөд итгэмжлэлийн хугацаанд гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхгүйгээр олгосон болно.

Тухайн итгэмжлэлийн хугацаа дууссан байхад тэтгэвэр тогтоолгогчийн нэрийн дансыг өөрчлөн тэтгэврийг шууд төлөөлөгчийн дансанд олгосон зөрчил илэрсэн. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2-т "Нас хөгширсөн, өвчилсөн гэх мэт хүндэтгэн үзэх шалтгааны улмаас

өөрийн биеэр тэтгэврээ авах чадваргүй болсон иргэний тэтгэврийг хууль ёсны итгэмжлэгдсэн хүнд нь, эсхүл нийгмийн даатгалын байгууллага гэрээр нь хүргэн өгч үйлчилнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй. 2023 оны 1 дүгээр сарын 23 өдөр зөрчлийг арилгасан байна.

2. Засгийн газрын 2020 оны 218 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтын 4.1-д “Байгууллагын үнэлгээний багийг төсвийн шууд захирагчийн шийдвэрээр байгууллагын нэгжийн удирдах албан тушаалтан болон хүний нөөц хариуцсан албан хаагчийн төлөөллөөс бүрдүүлэн жил бүрийн 6, 12 дугаар сард багтаан байгуулна. Хэрэв тухайн байгууллага зохион байгуулалтын нэгжгүй бол байгууллагын үнэлгээний баг шаардлагагүй бөгөөд энэ журамд заасан байгууллагын үнэлгээний багийн хийх ажлыг төсвийн шууд захирагч гүйцэтгэнэ” заасан заалтыг зөрчиж хагас жилээр ажилчин албан хаагчдын үр дүнг дүгнээгүй, урамшуулал олгоогүй.

3. 2021-2022 онд нярвын тайланг программаар хөтлөөгүй, орлого зарлага дутуу авсан шууд зардалд тайлагнасан, шаардах хуудасны гарын үсгийн бүрдэл дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5.” Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, нярвын тайланг хянан баталгаажуулдаггүй.

4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, “Энэ хуулийн 23.8-д заасан журмын дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй.

5. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны 06 дугаар сарын 20 өдрийн А/117 тоот тушаалаар “Сумын нийгмийн даатгалын байцаагчид шатахууны зардал олгох журам”- ыг баталж тус журмын 3-т “хэлтсийн үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогч нь сумын нийгмийн даатгалын байцаагчийн шатахууны зардлын тооцоог сар бүр хийж тухайн сарын эхэнд олгох ажлыг зохион байгуулна гэж заажээ.

2021 онд 2,711.7 мянган төгрөг, 2022 онд 7,326.8 мянган төгрөг нийт 10,038.5 мянган төгрөгийн шатахууны тооцоо бодоогүй нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаал, “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4. Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна, 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

6. Монгол улсын Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, 301 тушаал, Монгол улсын Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” 120 тушаал “ыг тус тус мөрдөж ажиллаагүй зөрчил илэрсэн.

2022 онд албан томилолтгүй, тушаал шийдвэргүйгээр замын зардал болох 359.3 мянган төгрөгийг олгосон байна.

Д/Д	Явсан маршрут	Нэр	ирсэн өдөр	явсан өдөр	КМ-ийн тооцро	томиллолтой эсэх	1 өдрийн томиллолын зардал	олгох дүн	олгосон	зөрүү
1	Дундговь - Дэрэн	Г. Ганцэцэг	2022.05.05	2022.05.07	70км *2 удаа	0	26,500	-	20,000	(20,000)
2	Дундговь - Сайхан-Овоо	Б. Долгоржав	2022.05.06			0	26,500	-	40,000	(40,000)
3	Дундговь - Өндөршил	Б. Сарантуяа	2022.05.04	2022.05.06	185км*2 удаа	0	26,500	-	26,000	(26,000)
4	Дундговь - Өлзийт	Г. Уранчимэг	2022.05.07	2022.05.10	100км*2 удаа	0	26,500	-	40,000	(40,000)
5	Дундговь - эрдэнэдалай	Т. эрдэнтуул	2022.05.05	2022.05.08	110 км*2 удаа	0	26,500	-	40,000	(40,000)
6	Дундговь - Баянжаргалан	Д. Мөнхзул	2022.04.04	2022.05.07	155 км*2 удаа	0	26,500	-	40,000	(40,000)
7	Дундговь - Дэлгэрхангай	Р. Мөнхцэцэг	2022.05.04	2022.05.07	150 км*2 удаа	0	26,500	-	40,000	(40,000)
8	Дундговь - Эрдэнэдалай	Э. Өлзиймаа	2022.05.05	2022.05.08	110км*2 удаа	0	26,500	-	20,000	(20,000)
9	Дундговь - Гурвансайхан	Б. Долгормаа	2022.05.05	2022.05.06	71 км*2 удаа	0	26,500	-	25,300	(25,300)
10	Дундговь -	Х. Оюунчимэг				0	26,500	-	28,000	(28,000)
11	Дундговь - Хулд	э. Хонгорзул	2022.05.04	2022.05.07	100км*2 удаа	0	26,500	-	28,000	(28,000)
	Нийт дүн						291,500	-	359,300	(359,300)

2022 онд албан томиллолтоор ажиллах хугацаанд албан хаагчдад байрны зардалд 1,111.0 мянган төгрөг олгоогүй байна.

Д/Д	Албан томиллолтоор явсан газар	Он сар өдөр	Нэрс	Хоног	1 өдрийн томиллолын зардал	Олгох мөнгө	Олгосон	Зөрүү
1	Сайхан овоо	2022.01.06	Н. Баттүвшин	1	26,500	26,500	12,000	14,500
2	Сайхан овоо	2022.01.06	А.Ганцог	1	26,500	26,500	12,000	14,500
3	Сайхан овоо	2022.01.06	М. Гармаа	1	26,500	26,500	12,000	14,500
4	Өмнөговь аймаг	2022.03.09	Г. Улаан наран	3	50,000	150,000	42,000	108,000
5	цагаандэлгэр	2022.03.09	Г. Улаан наран	1	26,500	26,500	24,000	2,500
6	цагаандэлгэр	2022.07.18	М. Гармаа	1	26,500	26,500	24,000	2,500
7	цагаандэлгэр	2022.07.18	х. Наранчимэг	1	26,500	26,500	24,000	2,500
19	эрдэнэдалай	2022.07.18	э. Мөнхзул	1	26,500	26,500	24,000	40,000
20	эрдэнэдалай	2022.07.18	г. Батжаргал	1	64,000	64,000	24,000	40,000
21	эрдэнэдалай	2022.08.29	Г. Улаан наран	1	64,000	64,000	24,000	40,000
22	эрдэнэдалай	2022.08.29	Ж. Энхжаргал	1	64,000	64,000	24,000	40,000
23	эрдэнэдалай	2022.08.29	Ц. Дэлгэрцэцэг	1	64,000	64,000	24,000	40,000
24	эрдэнэдалай	2022.08.29	Б. Мөнхчулуун	1	64,000	64,000	24,000	40,000
25	эрдэнэдалай	2022.08.29	Н. Гүрбадам	1	64,000	64,000	24,000	40,000
26	эрдэнэдалай	2022.08.29	Б. Ууганбаяр	1	64,000	64,000	24,000	40,000
27	эрдэнэдалай	2022.08.29	Т. Шинэбаяр	1	64,000	64,000	24,000	40,000
28	эрдэнэдалай	2022.08.29	Ц. Элбэгмаа	1	64,000	64,000	24,000	40,000
29	эрдэнэдалай	2022.08.29	Т. Лхагвасүрэн	1	64,000	64,000	24,000	40,000
30	эрдэнэдалай	2022.08.29	С. Гарамханд	1	64,000	64,000	24,000	40,000
31	Гурвансайхан, Өндөршил	2022.10.11	М. Гармаа	1	64,000	64,000	24,000	40,000
32	Гурвансайхан, Өндөршил	2022.10.11	э. Мөнхзул	3	64,000	192,000	112,000	80,000
33	Гурвансайхан, Өндөршил	2022.10.11	А. Ганцог	3	64,000	192,000	112,000	80,000
34	Гурвансайхан, Өндөршил	2022.10.11	Б. Урантөгс	3	64,000	192,000	112,000	80,000
35	Адаацаг	2022.10.11	Н. Баттүвшин	3	64,000	192,000	112,000	80,000
36	Адаацаг	2022.10.03	А. Алтантуяа	1	64,000	64,000	24,000	40,000
37	Адаацаг	2022.10.03	Н.Баттүвшин	1	64,000	64,000	24,000	40,000
38	улаанбаатар	2022.10.03	М.Мөнхцэцэг	1	64,000	64,000	24,000	40,000
	Дүн	2022.09.23	Г. Батжаргал	2	142,000	284,000	252,000	32,000
				38	1,567,000	2,321,000	1,210,000	1,111,000

7. 2021 онд дутуу олгосон албан томилолтын жагсаалт

/Хүснэгт 3/

№	Овог нэр	Хаана	Огноо	Тоо	1 хоног томилолт	Нийт олгох	Олгосон	Дутуу
1	Р. Нэргүй	дэлгэрцогт	2021.05.07	1	26,500	26,500	12,000	14,500
2	Б. Урантөгс	дэлгэрцогт	2021.05.07	1	26,500	26,500	12,000	14,500
3	Н. Баттүвшин	дэлгэрцогт	2021.05.07	1	26,500	26,500	12,000	14,500
4	М. Гармаа	дэлгэрцогт	2021.05.07	1	26,500	26,500	26,500	0
5	А. Ганцог	дэлгэрцогт	2021.03.24	1	26,500	26,500	26,500	0
6	Н. Баттүвшин	дэлгэрцогт	2021.03.24	1	26,500	26,500	26,500	0
7	М. Гармаа	дэлгэрцогт	2021.03.24	1	26,500	26,500	26,500	0
8	М.Мөнгөнцэцэг	дэлгэрцогт	2021.03.24	1	26,500	26,500	26,500	0
9	М.Гармаа	сайхан овоо	2021.03.31	1	26,500	26,500	26,500	0
10	Н. Баттүвшин	сайхан овоо	2021.03.31	1	26,500	26,500	26,500	0
11	А. Ганцог	сайхан овоо	2021.03.31	1	26,500	26,500	26,500	0
11	Э. Мөнгөнзул	сайхан овоо	2021.03.31	1	26,500	26,500	26,500	0
12	М.Гармаа	уб хот	2021.12.15	5	69,000	345,000	292,000	53,000
					387,000	663,000	552,000	111,000

Дээрх дутуу олгосон албан томилолтууд нь албан хаагчид суманд ажиллахдаа хоногоор явдаггүй өдөртөө ажиллаж ирдэг, томилолтын зардал хүрэлцээгүй төлөвлөгддөг учраас байрны зардал олгоогүй гэсэн тайлбарыг удирдлага, нягтлан бодогч нар өгсөн.

8. Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн А/26 тоот тушаалаар 6,480.0 мянган төгрөгийн урамшуулал олгох шийдвэр гаргаж, олгохдоо тушаалыг хамааралгүй заалт үндэслэсэн нь төсвийг зориулалтын бус зарцуулсан. Дээрх тушаалд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 6 дугаар сарын 7-ны А/96 тоот "2022 оны тодотгосон төсвийн хуваарь батлах тухай", Эрүүл мэндийн даатгалыг тухай хуулийн 19-д "Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын эх үүсвэр", 19.1.1, 19.1.2, 19.1.8-д "Шимтгэл, алдангийг цуглуулах, төвлөрүүлэх үйл ажиллагааг нийгмийн даатгалын байгууллага гүйцэтгэх бөгөөд үүнтэй холбогдсон харилцааг Нийгмийн даатгалын тухай хуулиар зохицуулна", 20.1.7-д "Нийгмийн даатгалын байгууллагын энэ хуулийн 19.3-т заасан үйл ажиллагааны зардал" гэсэн заалтуудыг үндэслэл болгон авсан зөрчилтэй.

ЕС: ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

2023 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн шинэчилсэн шилэн дансанд бүртгүүлж мэдээллээ иж бүрэн байршуулсан байна.

АРАВ. АВСАН АРГА ХЭМЖЭЭ МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ

Шалгалтын удирдамжийг танилцуулж, шалгалтыг холбогдох үндсэн баримтад тулгуурлан явуулж, шалгалтын явцад зөрчилтэй зүйлүүдэд тухай бүр нь нягтлан бодогч, нийгмийн даатгалын байцаагч нарт хууль, тогтоомжийн үндэслэлийг нь тайлбарлан зөвлөн туслаж, хамтран ажилласан.

АРВАН НЭГ. ШАЛГАЛТААР ӨГСӨН ДҮГНЭЛТ

2021-2022 онуудад урамшуулал олгох тушаал гаргахдаа хамааралгүй хуулийн заалт ашигласан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, нярвын тайлан хянадаггүй, эд хариуцагч ажилтан солигдох тухай бүр тооллого хийгээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад холбогдох хууль, эрхийн актыг баримталж ажиллаагүй зэрэг нь байгууллагын үйл ажиллагааг "Эрсдэлтэй буюу үйл ажиллагаагаа сайжруулах шаардлагатай" гэж дүгнэлээ. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сайн хэрэгжүүлэн ажилласан байна.

АРВАН ХОЁР. ШАЛГАЛТААР ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖ

Нийгмийн даатгалын ерөнхий газарт:

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого бүрдүүлэх чиг үүрэг бүхий орлого, шимтгэлийн тасгийн дарга, орлого шимтгэлийн байцаагч, эрүүл мэндийн даатгалын байцаагч, сумдын байцаагч нарт олгох урамшууллын тогтолцооны журмыг боловсруулан мөрдүүлэх, төсвийн төслийг үр дүнд суурилан төлөвлөх

Аймгийн нийгмийн даатгалын хэлтэст:

1. Засгийн газрын 2020 оны 218 тоот тогтоолын дагуу албан хаагчдын улирлын ажлын үр дүнг хагас жилээр дүгнэж хэвшиж, үр дүнг тооцож хуулийн дагуу урамшуулал олгож байх,

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5."Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг мөрдөж сар бүр шатахууны тооцоог бодох.

3. Монгол улсын Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" 120 тушаал "-ын дагуу албан томилолтыг тооцон олгож байх.

4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1-д "Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана" гэж заасны дагуу мэдэгдэл тухай бүр гаргаж баталгаажуулан, шилэн дансанд байршуулан, нийтэд мэдээлж хэвших

Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 5 дугаар сарын 25-ний дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан тоотоор хариу ирүүлэх.

ТАЙЛАН:

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ

БАЙЦААГЧ С.БАРХАСМАА

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ С.ЭНХТАЙВАН

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ Б.БАТСАЙХАН

ТАНИЛЦСАН:

ДУНДГОВЬ АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Г.БАТЖАРГАЛ

НЯГТЛАН БОДОГЧ Р.НЭРГҮЙ

**Нийгмийн даатгалын хамрагдалт, тэтгэвэр, тэтгэмж авагчдын мэдээ
2021 оны 01 сарын 01-ээс 12 дугаар сарын 31 өдөр**

Үзүүлэлт	Мөр	Аймаг, Дүүргийн нэр
Аж ахуйн нэгж байгууллага		
Шимтгэл төлөгч байгууллагын тоо	1	386
Даатгуулагчийн тоо	2	2,509
Цалингийн сан	3	16,976,275,724
Төсөвт байгууллага		
Шимтгэл төлөгч байгууллагын тоо	4	141
Даатгуулагчийн тоо	5	4,271
Цалингийн сан	6	43,759,660,710
Үүнээс: цэрэг цагдаагийн байгууллагын цалингийн сан	7	4,462,328,405
Сайн дурын		
Даатгуулагчийн тоо	8	4,097
Үүнээс		
Малчдын тоо	9	1,576
Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо	10	25
Шимтгэл тооцсон цалингийн сан	11	16,780,774,000
ЭМД-д хамрагдсан даатгуулагчийн тоо /13+14+...+18/	12	13,281
Үүнээс		
Тэр даатгалыг нь хариуцах иргэдийн тоо	13	8,442
Аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	14	1,102
Оюутан, суралцагчдын тоо	15	433
Малчдын тоо	16	3,304
Ял эдэлж буй хоригдлын тоо	17	-
Сайн дурын даатгуулагчийн тоо	18	-
Тэтгэврийн даатгалын сан		
Тэтгэвэр авагчдын тоо /20+21+22+23/	19	7,975
Үүнээс		
Өндөр насны тэтгэвэр	20	6,748
Тахир дутуугийн дэвтэр	21	840
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	22	241
Цэргийн тэтгэвэр	23	146
Тэтгэмжийн даатгалын сан		
Тэтгэмж авагчдын тоо /25+26+27+28/	24	2,868
Үүнээс		
ХЧТА-ны тэтгэмж	25	1,749
Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	26	846
Оршуулгын тэтгэмж	27	263
Өвчтөн сахисны тэтгэмж	28	
ҮОМШЭ-ний даатгалын сан		
Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо /20+21+22+23/	29	19
Үүнээс		
Тахир дутуугийн тэтгэвэр	30	16
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	31	1
Тэтгэмж, төлбөр	32	1
ҮОМШЭ-ний сувилал	33	1
Ажилгүйдлийн даатгалын сан		
Тэтгэмж авагчид, сургалтанд хамрагдсан хүний тоо /35+36/	34	243
Үүнээс		
Ажилгүйдлийн тэтгэмж	35	243
Сургалтанд хамрагдсан	36	
Эрүүл мэндийн даатгалын сан		
Тусламж үйлчилгээ авагчдын тоо /38+39+40/	37	
Үүнээс		
Эмчилгээ, үйлчилгээ	38	
Эмийн үнийн хөнгөлөлт	39	
Рашаан сувилал	40	

Нийгмийн даатгалын сангийн авлага, өглөгийн мэдээ 2021 оны 12 сарын 31 өдөр

Үзүүлэлт	Мөр	Аймаг, Дүүргийн нэр
АВЛАГА		
ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	1	591.23
ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	2	317.45
Үүнээс		
Аж ахуй нэгж байгууллагаас	3	314.11
Дараа сарын 05-ны дотор төлөх /0-30/	4	21.12
Урсгал авлага		
31-60 хоног	5	15.70
61-90 хоног	6	
91-120 хоног	7	36.06
Хуримтлагдсан авлага 121-ээс дээш	8	241.22
Төсөвт байгууллагаас	9	3.33
Дараа сарын 05-ны дотор төлөх /0-30/	10	3.33
Урсгал авлага		0.00
31-60 хоног	11	0.00
61-90 хоног	12	0.00
91-120 хоног	13	0.00
Хуримтлагдсан авлага 121-ээс дээш	14	0.00
Сайн дурын даатгуулагчаас	15	0.00
ӨГЛӨГ		0.00
ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	16	0.00
ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	17	0.00
Үүнээс		0.00
Эмнэлэгт	18	0.00
Эмийн санд	19	0.00
Бусад төсөвт байгууллагад	20	0.00
Бусад аж ахуй нэгж байгууллагад	21	0.00
Сайн дурын даатгуулагчид	22	0.00

Үзүүлэлт	Мөр	Аймаг, Дүүргийн нэр		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл /2+4+17+29+41+52/	1	-	4,085.62	
Төвлөрсөн харилцах дансны эхний үлдэгдэл	2		1.47	
Төвлөрсөн харилцах дансны эцсийн үлдэгдэл	3		0.15	
Тэтгэврийн даатгалын сан				
Харилцах дансны эхний үлдэгдэл	4		3,886.75	
Орлогын дүн /6+8+9/	5	12,195.95	37,787.44	(25,591.49)
Үүнээс				
Санд хуваарилсан мөнгө	6	12,195.95	12,092.53	103.42
Үүнээс: Шимтгэлийн орлого	7	12,195.95	13,232.32	(1,036.37)
Төсвийн татаас	8		24,267.95	(24,267.95)
Бусад орлого	9		1,426.96	(1,426.96)
Зарлагын дүн /11+12+13+14+15/	10	37,763.88	38,246.08	(482.20)
Үүнээс				
Өндөр насны тэтгэвэр	11	31,644.86	31,770.46	(125.60)
Тахир дутуугийн тэтгэвэр	12	3,594.42	3,328.98	265.44
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	13	920.99	941.82	(20.83)
Цэргийн тэтгэвэр	14	1,194.50	1,193.46	1.04
Бусад зарлага	15	409.10	1,011.36	(602.26)
Харилцах дансны эцсийн үлдэгдэл /4+5-10/	16	(25,567.93)	3,428.11	(28,996.04)
Тэтгэмжийн даатгалын сан				
Харилцах дансны эхний үлдэгдэл	17	-	140.85	(140.85)
Орлогын дүн /19+21/	18	970.28	2,128.16	(1,157.88)
Үүнээс				
Санд хуваарилсан мөнгө	19	967.42	1,126.84	(159.42)
Үүнээс: Шимтгэлийн орлого	20	967.42	1,155.98	(188.56)
Бусад орлого	21	2.86	1,001.32	(998.46)
Зарлагын дүн /23+24+25+26+27/	22	2,140.48	2,098.68	41.80
Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж	23	331.77	328.35	3.42
Жирэмсэн ба амарсны тэтгэмж	24	1,352.83	1,423.42	(70.59)
Оршуулгын тэтгэмж	25	284.00	263.00	21.00
Өвчтэн сахисны тэтгэмж	26	101.17	83.34	17.83
Бусад зардал	27	70.69	0.57	70.12
Харилцах дансны эцсийн үлдэгдэл /17+18-22/	28	1,170.20	170.33	999.87
ҮОМШӨ - ний даатгалын сан				
Харилцах дансны эхний үлдэгдэл	29	-	14.18	(14.18)
Орлогын дүн /31+33/	30	577.77	777.71	(199.94)
Үүнээс				
Санд хуваарилсан мөнгө	31	575.68	732.24	(156.56)
Үүнээс: Шимтгэлийн орлого	32	575.68	740.17	(164.49)
Төсвийн татаас	33	-	-	-
Бусад орлого	34	2.09	45.47	(43.38)
Зарлагын дүн /35+36+37+38+39/	35	200.83	768.28	(567.45)
Тахир дутуугийн тэтгэвэр	36	98.38	98.92	(0.54)
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	37	4.69	4.20	0.49
Тэтгэмж, төлбөрт	38	17.18	0.24	16.94
ҮОМШӨ-ний сувиллын зардал	39	2.78	0.04	2.74
Бусад зардал	40	77.78	664.87	(587.09)
Харилцах дансны эцсийн үлдэгдэл /29+30-34/	41	376.93	23.62	353.31
Ажилгүйдлийн даатгалын сан				
Харилцах дансны эхний үлдэгдэл	42	-	41.98	(41.98)
Орлогын дүн /43+45/	43	184.35	422.83	(238.48)
Үүнээс				
Санд хуваарилсан мөнгө	44	184.35	209.78	(25.43)
Үүнээс: Шимтгэлийн орлого	45	184.35	195.28	(10.93)
Бусад орлого	46	-	213.05	(213.05)
Зарлагын дүн /47+48+49+50/	47	435.31	440.90	(5.59)
Ажилгүйдлийн тэтгэжид	48	419.21	419.39	(0.18)
Сургалтын зардал	49			
Хөдөлмөр зохицуулалтын албаны зардал	50			
Бусад зардал	51	16.10	21.51	(5.41)
Харилцах дансны эцсийн үлдэгдэл /41+42-46/	52	250.95	23.91	227.04
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл /3+16+28+41+52/	53	(26,612.14)	3,646.18	(30,258.32)

**Нийгмийн даатгалын хамрагдалт, тэтгэвэр, тэтгэмж авагчдын мэдээ
2022 оны 01 сарын 01-ээс 12 дугаар сарын 31 өдөр**

Үзүүлэлт	Мөр	Аймаг, Дүүргийн нэр
Аж ахуйн нэгж байгууллага	1	
Шимтгэл төлөгч байгууллагын тоо	2	384
Даатгуулагчийн тоо	3	2,499
Цалингийн сан		19,541,463,233
Төсөвт байгууллага	4	143
Шимтгэл төлөгч байгууллагын тоо	5	4,399
Даатгуулагчийн тоо	6	49,927,151,424
Цалингийн сан	7	4,877,525,362
Үүнээс: цэрэг цагдаагийн байгууллагын цалингийн сан		
Сайн дурын	8	3,769
Даатгуулагчийн тоо		
Үүнээс		1,251
Малчдын тоо	9	10
Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо	10	17,052,334,000
Шимтгэл тооцсон цалингийн сан	11	14,140
ЭМД-д хамрагдсан даатгуулагчийн тоо /13+14+...+18/	12	
Үүнээс		7,728
Тэр даатгалыг нь хариуцах иргэдийн тоо	13	969
Аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	14	346
Оюутан, суралцагчдын тоо	15	5,097
Малчдын тоо	16	-
Ял эдэлж буй хоригдлын тоо	17	
Сайн дурын даатгуулагчийн тоо	18	
Тэтгэврийн даатгалын сан	19	8,218
Тэтгэвэр авагчдын тоо /20+21+22+23/		
Үүнээс		7,016
Өндөр насны тэтгэвэр	20	809
Тахир дутуугийн дэвтэр	21	233
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	22	160
Цэргийн тэтгэвэр	23	
Тэтгэмжийн даатгалын сан	24	2,172
Тэтгэмж авагчдын тоо /25+26+27+28/		
Үүнээс		1,280
ХЧТА-ны тэтгэмж	25	678
Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	26	214
Оршуулгын тэтгэмж	27	
Өвчтөн сахисны тэтгэмж	28	
ҮОМШЭ-ний даатгалын сан	29	28
Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо /20+21+22+23/		
Үүнээс		17
Тахир дутуугийн тэтгэвэр	30	1
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	31	8
Тэтгэмж, төлбөр	32	2
ҮОМШЭ-ний сувилал	33	
Ажилгүйдлийн даатгалын сан	34	297
Тэтгэмж авагчид, сургалтанд хамрагдсан хүний тоо /35+36/		
Үүнээс		297
Ажилгүйдлийн тэтгэмж	35	
Сургалтанд хамрагдсан	36	
Эрүүл мэндийн даатгалын сан	37	
Тусламж үйлчилгээ авагчдын тоо /38+39+40/		
Үүнээс		38
Эмчилгээ, үйлчилгээ	38	39
Эмийн үнийн хөнгөлөлт	39	40
Рашаан сувилал	40	

Нийгмийн даатгалын сангийн авлага, өглөгийн мэдээ 2022.. оны 12 сарын 31 өдөр

Үзүүлэлт	Мөр	Аймаг, Дүүргийн нэр
АВЛАГА		
ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	1	596.19
ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	2	549.94
Үүнээс		
Аж ахуй нэгж байгууллагаас	3	544.32
Дараа сарын 05-ны дотор төлөх /0-30/	4	3.12
Урсгал авлага		
31-60 хоног	5	5.12
61-90 хоног	6	21.47
91-120 хоног	7	31.25
Хуримтлагдсан авлага 121-ээс дээш	8	483.34
Төсөвт байгууллагаас	9	5.62
Дараа сарын 05-ны дотор төлөх /0-30/	10	5.62
Урсгал авлага		
31-60 хоног	11	
61-90 хоног	12	
91-120 хоног	13	
Хуримтлагдсан авлага 121-ээс дээш	14	
Сайн дурын даатгуулагчаас	15	
ӨГЛӨГ		
ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	16	
ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	17	
Үүнээс		
Эмнэлэгт	18	
Эмийн санд	19	
Бусад төсөвт байгууллагад	20	
Бусад аж ахуй нэгж байгууллагад	21	
Сайн дурын даатгуулагчид	22	

Үзүүлэлт	Мөр	Аймаг, Дүүргийн нэр		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл /2+4+17+29+41+52/	1		3,646.18	
Төвлөрсөн харилцах дансны эхний үлдэгдэл	2		0.16	
Төвлөрсөн харилцах дансны эцсийн үлдэгдэл	3		-	
Тэтгэврийн даатгалын сан				
Харилцах дансны эхний үлдэгдэл	4	-	3,428.11	(3,428.11)
Орлогын дүн /6+8+9/	5	19,713.85	55,338.61	(35,624.76)
Үүнээс				
Санд хуваарилсан мөнгө	6	13,269.00	12,956.17	312.83
Үүнээс: Шимтгэлийн орлого	7	13,269.00	13,039.60	229.40
Төсвийн татаас	8	6,427.31	42,189.53	(35,762.22)
Бусад орлого	9	17.54	192.91	(175.37)
Зарлагын дүн /11+12+13+14+15/	10	51,383.99	53,390.01	(2,006.02)
Үүнээс				
Өндөр насны тэтгэвэр	11	43,456.00	43,200.10	255.90
Тахир дутуугийн тэтгэвэр	12	4,618.45	4,289.42	329.03
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	13	1,359.54	1,236.77	122.77
Цэргийн тэтгэвэр	14	1,470.70	1,502.32	(31.62)
Бусад зарлага	15	479.30	3,161.40	(2,682.10)
Харилцах дансны эцсийн үлдэгдэл /4+5-10/	16	(31,670.14)	5,376.71	(37,046.85)
Тэтгэмжийн даатгалын сан				
Харилцах дансны эхний үлдэгдэл	17		170.33	(170.33)
Орлогын дүн /19+21/	18	1,312.06	2,075.01	(762.95)
Үүнээс				
Санд хуваарилсан мөнгө	19	1,310.30	1,305.77	4.53
Үүнээс: Шимтгэлийн орлого	20	1,310.30	1,338.67	(28.37)
Бусад орлого	21	1.76	769.24	(767.48)
Зарлагын дүн /23+24+25+26+27/	22	2,179.69	1,983.80	195.89
Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж	23	351.90	279.57	72.33
Жирэмсэн ба амарсны тэтгэмж	24	1,289.44	1,155.20	134.24
Оршуулгын тэтгэмж	25	327.00	221.00	106.00
Өвчтэн сахисны тэтгэмж	26	147.24	77.60	69.64
Бусад зардал	27	64.11	250.43	(186.32)
Харилцах дансны эцсийн үлдэгдэл /17+18-22/	28	(867.63)	261.53	(1,129.16)
ҮОМШӨ - ний даатгалын сан				
Харилцах дансны эхний үлдэгдэл	29		23.62	(23.62)
Орлогын дүн /31+33/	30	1,064.21	911.36	152.85
Үүнээс				
Санд хуваарилсан мөнгө	31	1,010.50	857.59	152.91
Үүнээс: Шимтгэлийн орлого	32	1,010.50	851.45	159.05
Төсвийн татаас	33	53.71	53.71	-
Бусад орлого	34	37.32	0.55	36.77
Зарлагын дүн /35+36+37+38+39/	35	151.52	829.67	(678.15)
Тахир дутуугийн тэтгэвэр	36	119.83	106.27	13.56
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	37	8.40	5.85	2.55
Тэтгэмж, төлбөрт	38	19.31	5.57	13.74
ҮОМШӨ-ний сувиллын зардал	39	3.98	0.89	3.09
Бусад зардал	40	64.60	711.89	(647.29)
Харилцах дансны эцсийн үлдэгдэл /29+30-34/	41	1,026.89	105.31	921.58
Ажилгүйдлийн даатгалын сан				
Харилцах дансны эхний үлдэгдэл	42		23.90	(23.90)
Орлогын дүн /43+45/	43	225.10	671.22	(446.12)
Үүнээс				
Санд хуваарилсан мөнгө	44	224.68	226.07	(1.39)
Үүнээс: Шимтгэлийн орлого	45	224.68	232.74	(8.06)
Бусад орлого	46	0.46	445.14	(444.68)
Зарлагын дүн /47+48+49+50/	47	546.07	622.00	(75.93)
Ажилгүйдлийн тэтгэжид	48	532.80	621.93	(89.13)
Сургалтын зардал	49			-
Хөдөлмөр зохицуулалтын албаны зардал	50			-
Бусад зардал	51	13.30	0.07	13.23
Харилцах дансны эцсийн үлдэгдэл /41+42-46/	52	1,026.43	73.13	953.30
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл /3+16+28+41+52/	53	(30,484.45)	5,816.67	(36,301.12)

Үзүүлэлт	Акт		Улсын төсөвт	Орон нутгийн төсөвт	Тухайн байгууллагад	Иргэнд	Албан шаардлага		Зөвлөмж тоо
	тоо	мөнгөн дүн					тоо	мөнгөн дүн	
1 Дундговь	0	0	0	0	0	0	1	10,038,500	4